



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1."Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлал"-ыг хавсралт ёсоор баталсугай.
- 2.Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т, хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд тус тус үүрэг болгосугай.
- 3.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН

ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгон авч буй тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд энэ аргачлалыг мөрдөнө.

Хоёр.Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх

2.1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан дараах томъёог ашиглан нэмэгдүүлнэ:

$$T_i = T_{i-1} + T_{i-1} * (XY\Theta_{T_{i-1}} + (I_{i-2} - XY\Theta_{T_{i-2}}))$$

T_i -тухайн онд нэмэгдсэн тэтгэврийн хэмжээ;

T_{i-1} -өмнөх оны тэтгэврийн хэмжээ;

$XY\Theta_{T_{i-1}}$ -Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг баталсан хуулийн төсвийн хүрээний мэдэгдэлд заасан өмнөх оны хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;

$XY\Theta_{T_{i-2}}$ -Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг баталсан хуулийн төсвийн хүрээний мэдэгдэлд заасан 2 жилийн өмнөх хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;

I_{i-2} -Үндэсний статистикийн хорооноос зарласан 2 жилийн өмнөх инфляцын жилийн дундаж түвшин;

i -тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж байгаа он.

Тайлбар: Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх томъёоны $(I_{i-2} - XY\Theta_{T_{i-2}})$ үзүүлэлтийг 2025 онд тэг, 2026 оноос эхлэн өмнөх онд шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын хувьд тэг байхаар тус тус тооцно.

2.2.Энэ аргачлалын 2.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн дүн дээр Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу олгосон нэмэгдэл (50,000 төгрөг)-ийг нэмж бодно.

2.3.Тэтгэвэр бодох цалинд хэрэглэх итгэлцүүрээр тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ энэ аргачлалд хамаарахгүй.

Гурав.Хяналт, хариуцлага

3.1.Энэ аргачлалын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

3.2.Энэ аргачлалыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----